



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/207

Чойр

Цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улс байгуулагдсаны 815, 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Говьсүмбэр аймгийн баяр наадмын сурын харвааны эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байр эзэлсэн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын харьяат Эрдэнэцогтын Энх-Амгаланд “Аймгийн Мэргэн” цол, дэд байр эзэлсэн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын харьяат Ганбаатарын Бэлэгсайханд “Аймгийн Гарамгай харваач” цол, гутгаар байр эзэлсэн Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын харьяат Гомбосүрэнгийн Гантулгат “Аймгийн Гоц харваач” цол, дөтгөөр байр эзэлсэн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын харьяат Батдэлгэрийн Жаргалсайханд “Онч харваач” цол, тав дугаар байр эзэлсэн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын харьяат Чулуунбаатарын Батцэрэнд “Тод харваач” цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ